



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2018 оны 3 дугаар сар

Улаанбаатар
2018



МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Нийт мөнгөний нийлүүлэлт
16.1 их наяд ₮ байна



M2 мөнгөний жилийн өсөлт 31.1 хувьд хүрч өмнөх сарынхаас 2 нэгж хувиар нэмэгдсэн байна. Нийт мөнгөний нийлүүлэлтийн 55.1 хувийг төгрөгийн хадгаламж, 15.6 хувийг валютын хадгаламж, 13.7 хувийг төгрөгийн харилцах, 12 хувийг валютын харилцах бүрдүүлжээ.

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг сүүлийн 6 сар дараалан чангарч байгаа нь иргэд валютын хадгаламжаасаа төгрөгийн хадгаламж руу шилжэх хөдөлгөөнд нөлөөлж байна.

Иргэдийн валютын хадгаламж ₮-ийн хадгаламж руу шилжих шилжилт үргэлжилж байна



Нийт мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 161.5 тэрбум ₮ (1%)-өөр өсөв



Иргэд, байгууллагын төгрөгийн хадгаламж, харилцах тайлант сард нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийг өсгөв.


Нийт төгрөгийн хадгаламжийн 85.2 хувь, валютын хадгаламжийн 72.2 хувийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна.

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр активын дүн 17.7 их наяд төгрөг, гадаад цэвэр актив -1.5 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Нийт дотоод активын 14.1 их наяд төгрөг нь эдийн засагт зээл хэлбэрээр байршиж байна.

Тайлант сард нөөц мөнгө 2.8 хувиар буурч 2.9 их наяд төгрөгт хүрчээ. Үүний 71.2 хувийг банкуудын харилцах, 19.8 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 9 хувийг банкуудын касс дахь мөнгө бүрдүүлж байна.

БАНКУУДЫН ЗЭЭЛ

Нийт зээлийн үлдэгдэл 14. их наяд ₮ -г хүрч, жилийн 11.4% өсөв



Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 19.1 хувиар өсч 7 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 4.5 хувиар өсч 6.9 их наяд төгрөгт тус тус хүрчээ.

Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 1,227.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 34.1 тэрбум төгрөгөөр буурсан нь чанаргүй зээл төлөгдсөн болон ангилал сайжирснаар тайлбарлагдаж байна.


Тайлант сард 1414.1 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1107.4 тэрбум ₮ эргэн төлөгдлөө



Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 148.1 тэрбум төгрөгөөр, төлөгдсөн зээл 24.2 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.5 нэгж хувиар, хугацаа хэтэрсэн зээлийнх 0.6 нэгж хувиар тус тус буурчээ. Хувийн байгууллагын зээлийн нийт хугацаа хэтэрсэн зээлийн 82.7 хувийг, чанаргүй зээлийн 81.5 хувийг тус тус бүрдүүлж байна.

Чанаргүй зээлийн дийлэнх уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ногдож байна




Чанаргүй зээл нийт зээлийн 8.7%, Хугацаа хэтэрсэн зээл 6.6% байна




Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 108.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь худалдааны салбарын зээл 82.3 тэрбум төгрөг, уул уурхай салбарын зээл 58 тэрбум төгрөгөөр өссөнөөр голлон тайлбарлагдаж байна.

Хувийн байгууллагад олгосон зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах үйлдвэр, барилгын салбар эзэлж байна



- Уул уурхай олборлолт
- Барилга
- Бусад
- Боловсруулах үйлдвэр
- Худалдаа


ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдааны салбар, боловсруулах үйлдвэрлэлийн зээл эзэлж байна.



- Худалдаа
- Боловсруулах үйлдвэрлэл
- Үйлчилгээ
- Бусад
- Барилга
- Хөдөө аж ахуй

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 207.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Тодруулбал, цалин, тэтгэврийн зээл 67.0 тэрбум, автомашины зээл 28.9 тэрбум, орон сууцны ипотекийн зээл 32.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Иргэдийн зээлийн 44.1 хувийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар) бүрдүүлж байна



- Цалин, тэтгэврийн зээл
- Хадгаламж барьцаалсан зээл
- Картын зээл
- Автомашины зээл
- ОСИЗ /МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар/
- Бусад

ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 2.6 их наяд төгрөгт хүрснээс 27.8 хувийг худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 21.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 8.2 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 14.2 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.2 их наяд төгрөгт, зээлдэгчдийн тоо 93,099-т хүрчээ. Нийт зээлийн 859.3 тэрбум төгрөг буюу 20.2 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 760.3 тэрбум төгрөг буюу 17.9 хувь нь орон нутагт ногдож байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.3 хувиар өсчээ.



Тайлант сард банкууд 632 зээлдэгчид 49.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 44.9 хувь нь хөтөлбөрийн, 55.1 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Ипотекийн зээлийн хувьд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл өсч байна.



Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 60.2 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 32.9 хувийг хөтөлбөрийн зээл, 6.9 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.1 хувь нь хөтөлбөрийн зээл, 19.9 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 3.0 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. Харин орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 78.7 хувь нь хөтөлбөрийн зээл, 20.7 хувь нь өөрийн эх үүсвэрээр, 0.6 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Нийт ипотекийн зээлийн 77.1 хувь нь хөтөлбөрийн зээл байна



Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.7 хувь нь хэвийн, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй зээл байна.

Ипотекийн зээлийн хүү өмнөх сараас 0.6 нэгж хувиар буурчээ




Нийт зээлдэгчдийн 69.3 хувь нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой бөгөөд 74.9 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авчээ.

¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.6 хувь буюу 3856.3 тэрбум төгрөг 80м2 хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ.

Нийт ипотекийн зэээл авсан зээлдэгчдийн 77.3 хувь нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 81.0 хувийг эзэмшиж байна.

Ипотекийн зээлийн 82.1 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ



ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ

Тайлант сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ханш голлох валютуудын эсрэг суларч ам.доллар болон рублийн эсрэг чангарчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш өмнөх сарынхаас 0.3 хувиар чангарч 2395.4 төгрөг байв. Тухайн сарын хамгийн өндөр ханш 2398.7 төгрөг байсан бол хамгийн бага нь 2392.8 төгрөг байв. Сарын эцсийн төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх сараас 0.1 хувиар чангарчээ.

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг аажмаар чангарч байна



Харин БНХАУ-ын юаньтай харьцах дундаж ханш өмнөх сараас 0.1 хувиар суларч 379.1 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 377 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 382.8 төгрөг байлаа. Харин сарын эцсийн ханш 381.4 төгрөг буюу өмнөх сараас 1.2 хувиар чангарсан байна.

Сарын дунджаар төгрөгийн ханш юаны эсрэг чангарч байна



ХҮҮ

Төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарын түвшинд хадгалагдаж байна. Тодруулбал тайлант сард шинээр олгосон зээлийн хүү жилийн 19.1, зээлийн үлдэгдлээр жигнэсэн хүү 18.1 хувьтай байна. Валютын зээлийн хувьд шинээр олгосон зээлийн хүү 0.2 нэгж хувиар, үлдэгдлээр жигнэсэн хүү 0.1 нэгж хувиар тус тус буурч, харгалзан 11.3 хувь болон 11 хувь болжээ.

Тайлант сард шинээр татсан хадгаламжийн хүү өмнөх сараас 0.5 нэгж хувиар, үлдэгдлээр жигнэж тооцсон хадгаламжийн хүү 0.1 нэгж хувиар тус тус буурч, харгалзан 11.4 хувь болон 12.8 хувь байна.

Зээлийн хүү өмнөх сараас өөрчлөлтгүй



Иргэдэд төгрөгөөр олгосон зээлийн дундаж хүү 19.8 хувь, хувийн хэвшилд олгосон зээлийн хувьд 18.1 хувь байна. Зээлийн хугацаа 36 сараас дээш болоход хүү бага зэрэг буурч байна. Иргэдийн валютын зээлийн хүү 14.8 хувь, хувийн хэвшлийнх 11.0 хувь байна.

Хадгаламжийн хүү буурчээ



Шинээр татсан валютын хадгаламжийн хүү өмнөх сараас 0.5 нэгжээр буурсан бол валютын хадгаламжийн үлдэгдлээр жигнэж тооцсон хүү өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

ИНФЛЯЦИ

Улсын хэмжээнд инфляци 2018 оны 3 дугаар сарын байдлаар жилийн 6.6 хувь, сарын 0.9 хувьтай байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд жилийн инфляци 7.7 хувь байна. Улаанбаатар хотын жилийн инфляцийн 6.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 1.6 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хатуу түлш, тээвэр, хувцас, эм, тариа эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт гол нөлөө үзүүлжээ. Харин хүнсний барааны бүлгийн үнэд сүү, сүүн бүтээгдэхүүн болон талх нарийн боов, хүнсний ногооны үнийн өсөлт нөлөөлжээ.

УБ хотын хэмжээнд сарын инфляци 1.2 хувьтай гарсан нь хүнсний барааны үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Тодруулбал, сарын инфляцийн ¾ буюу 0.9 нэгж хувийг хүнсний барааны, 0.3 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт тодорхойлж байна. Хүнсний барааны үнийн өсөлтийн дийлэнх хувийг махны үнийн өсөлт бүрдүүлэв.

Махны бүлгийн үнэ тайлант сард 7.9 хувиар, хүнсний ногооны бүлгийн үнэ 4.6 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүнийн бүлгийн үнэ 2.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

УБ хотын жилийн инфляци 7.7 хувь




Сарын инфляци 1.2 хувь



МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Зураг 1.3. Нөөц мөнгөний бүтэц



Зураг 1.2. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.4. Төв банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод актив



ЗЭЭЛ

Зураг 2.1. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/




Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл




Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл



Зураг 2.7. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл



Зураг 2.9. Орон нутгийн зээлийн үлдэгдэл болон чанаргүй зээл




Зураг 2.4. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)



Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн (тэрбум ₮)



Зураг 2.8. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.10. Олгосон, төлөгдсөн зээл, зээлдэгчдийн тоо




ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.3. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар



Зураг 3.5. Ипотекийн зээлээр худалдан аьсан орон сууцны байршил, Улаанбаатар хот




Зураг 3.2. Ипотекийн зээлийн үлдэгдэл аймгуудаар



Зураг 3.4. Тайлант сард шинээр олгосон зээл




Зураг 3.6. Барьцаа хөрөнгийн байршил, орон нутаг



Зураг 3.7. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он




Зураг 3.9. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт



Зураг 3.11. Ипотекийн зээлийн авсан зээлдэгчийн тоо, хөдөлмөр эрхэлж буй байгууллагын үйл ажиллагааны салбараар



Зураг 3.8. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.10. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

